

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/137/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: Lundegmaa.Ts@audit.gov.mn

Аудитор:

О.Нарангарав

Утас: 70523020

Цахим хаяг: Narangerav.O@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	Зардлын данстай холбоотой	12
3.1.1	Илрүүлэлт:	12
3.1.2	Эрсдэл:	12
3.1.3	Өгсөн зөвлөмж:	12
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 <u>2019-02-18</u> № <u>1-6/74</u> танай _____ -ны № _____ -т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА Г.БАТМӨНХ ТАНАА
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Н.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Батмөнх-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.12-наас 2019.02.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.23-ны өдрийн 01/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилго, стратегийн зорилтын хүрээнд хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд төрийн захиргааны хяналт тавих замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, чанартай ажил үйлчилгээг хэрэглэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдийн таатай орчин бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилго, стратегийн зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх замаар амьдрах, ажиллах, сурч боловсрох, чанартай хүртээмжтэй тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангуулах замаар иргэдэд аюулгүй хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Байгалийн нөөц баялгийн зохистой ашиглалтыг сайжруулж хүний хүчин зүйлээс шалтгаалсан байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл, хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангуулна.
- Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангуулах замаар нийтийн аюулгүй байдлыг хангуулна.
- Хилийн боомтод хийгдэх хяналт шалгалтыг сайжруулж, олон улсын хүний хөл хориот болон мал, амьтны халдварт өвчин, ургамлын хорио цээрт зүйл улсын хилээр нэвтрэхээс сэргийлж, экспорт, импортын бараа, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулна.
- Хүнсний аюулгүй байдлын итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж, хүнс болон эмийн аюулгүй байдлыг хангуулна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд
- Сангийн сайдын төсвийн үйл ажиллагаатай холбоотой тушаалууд
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох хууль тогтоомж

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Цалингийн бүртгэлийн Payroll, НББ-ийн EMERALD” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгийн дүн нийт зарлагын дүнгээс бага байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны 12 сарын 31-рх тайлангийн нийт зардлын дүн 2,360.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 23.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,860.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	364.1	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	2,224.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Үр дүнгийн тайлангаар гэрэл цахилгааны зардлыг 442.7 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардлыг 811.7 мянган төгрөгөөр илүү, түлш халаалтын зардлыг 1,254.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Иж бүрэн байх, Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Төрийн үйлчилгээний 5 албан хаагчдад 356.1 мянган төгрөгийн буудлын мөнгийг илүү тооцон олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1294.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт,

хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,230.6 сая төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь Орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор цалин, НДШ-ийн зардал 51.3 сая төгрөгөөр хэмнэгдэж, тогтмол зардал 12.7 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь шалтгаалжээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь 2018 онд улсын төсвөөс 1,294.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,031.1 сая төгрөг нийт 2,325.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 917.8 сая төгрөг нь нийт зардлын 39.6 хувь, бараа үйлчилгээний урсгал зардал 312.5 сая төгрөг нь нийт зардлын 13.4 хувь, үйл ажиллагааны орлогын төвлөрүүлэлт 1,031.1 сая төгрөг нь нийт зардлын 44.3 хувь, зарцуулагдаагүй зардлын төвлөрүүлэлт 64.5 сая төгрөг нь нийт зардлын 2.8 хувийг тус тус эзэлж байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

3.1.1 Илрүүлэлт:

Үйл ажиллагааны зардлаас 1,860.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулан гүйлгээ хийсэн байна. Үүнд:

- Эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас Хог хаягдлын хураамжийн төлбөр 120.0 мянган төгрөгийг төлсөн
- Түлш халаалтын зардлаас 1,740.7 мянган төгрөгөөр шатахуун худалдан авсан.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 16.5.5, дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавартай”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардал буруу тайлагнагдах, төсөв буруу батлагдах эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан тайлагнаж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06-р сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,898,694.49	167,390,923.99
33	АВЛАГА	728,827.00	529,200.00
33510	Байгууллагаас авах авлага	199,627.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	529,200.00	529,200.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	200,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	0.00	200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	144,169,867.49	166,661,723.99
35100	Түүхий эд материал	66,830,765.35	60,105,029.75
35110	Тусгай зориулалттай материал	18,470,422.06	17,089,679.61
35130	Эм боох материал	48,360,343.29	43,015,350.14
35300	Бэлэн бүтээгдэхүүн	20,712,080.40	43,635,249.72
35400	Хангамжийн материал	56,627,021.74	62,921,444.52
35410	Бичиг хэргийн материал	5,941,530.79	10,201,319.97
35420	Аж ахуйн материал	37,809,087.61	32,608,824.53
35430	Сэлбэг хэрэгсэл	4,349,638.50	5,821,844.50
35440	Түлш, шатах тослох материал	1,890,000.00	5,640,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,636,764.84	8,649,455.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	373,691,335.00	549,853,457.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	373,691,335.00	549,853,457.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	151,000,461.00	152,627,853.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,223,490.35	-32,620,998.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	154,101,880.00	170,951,980.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-138,520,281.74	-115,989,013.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	258,461,794.75	290,905,050.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-239,137,096.60	-244,376,358.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,284,258.98	43,653,166.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,152,881.61	-24,362,764.14
39209	Зам, гүүрийн байгууламж	148,807,199.00	148,807,199.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-18,598,357.80	-22,315,992.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,214,172,278.51	1,346,406,978.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,138,504,429.14	-1,163,833,643.57
39301	Програм хангамж	713,000.00	713,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-713,000.00	-713,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	518,590,029.49	717,244,381.03
41300	Өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	518,590,029.49	717,244,381.03
51	Засгийн газрын хувь оролцоо	518,590,029.49	717,244,381.03
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	826,431,282.30	826,431,282.30
51200	Хуримтлагдсан үр дүн	-307,841,252.81	-114,864,262.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-303,083,118.95	-307,841,252.81
51220	Тайлант үеийн үр дүн	-4,758,133.86	192,976,990.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	5,677,361.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	518,590,029.49	717,244,381.03

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,491,672,096.67	2,566,299,753.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,326,927,492.67	1,271,528,753.05
120	Нийтлэг татварын бус орлого	1,326,927,492.67	1,271,528,753.05
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,326,927,492.67	1,271,528,753.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	898,427,486.00	1,031,148,084.30
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	428,500,006.67	240,380,668.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,164,744,604.00	1,294,771,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	0.00
133	Төсвийн захирагчдаас	1,154,744,604.00	1,294,771,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,744,604.00	1,294,771,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,495,921,234.66	2,360,805,030.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,495,921,234.66	2,360,805,030.55
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,032,429.66	1,223,728,742.91
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	809,786,196.00	818,475,586.38
210101	Үндсэн цалин	641,079,496.00	580,012,986.38
210102	Нэмэгдэл цалин	102,128,000.00	187,337,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,848,000.00	34,848,000.00
210105	Гэрээт ажлын цалин	31,730,700.00	16,277,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,817,200.00	99,143,459.28
210201	Тэтгэврийн даатгал	58,782,012.73	66,246,932.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,041,667.84	8,268,428.00
210203	ҮОМШ өвчний даатгал	7,859,804.82	6,567,454.36
210204	Ажилгүйдлын даатгал	1,648,518.98	1,641,712.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,485,195.63	16,418,932.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,344,100.00	29,491,673.00
210301	Гэрэл цахилгаан	6,492,600.00	11,709,993.00
210302	Түлш, халаалт	537,600.00	1,254,400.00
210304	Байрны түрээс	21,313,900.00	16,527,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,105,272.80	63,032,666.28
210401	Бичиг хэрэг	6,262,754.31	11,447,051.61
210402	Тээвэр шатахуун	13,723,408.00	17,717,600.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,066,557.00	12,467,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,452,563.14	222,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,599,990.35	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	21,177,614.67
2105	Нормативт зардал	25,903,030.61	76,238,027.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,679,146.96	74,641,498.12
210502	Хоол, Хүнс	2,223,883.65	1,596,529.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,312,800.00	31,161,109.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	14,626,820.28
210604	Урсгал засвар	9,312,800.00	16,534,288.72
2107	Томилолт, зочны зардал	9,618,870.00	6,758,030.00
210702	Дотоод албан томилолт	9,618,870.00	6,758,030.00

Замын Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,772,008.97	33,807,584.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	2,248,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	477,080.00	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	704,584.00	950,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,413,880.48	3,177,930.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,544,464.49	26,250,854.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	452,372,951.28	65,620,607.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	308,100.00	2,808,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	452,064,851.28	62,812,507.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,013,888,805.00	1,137,076,287.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,001,820.00	41,758,656.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,765,216.00	3,984,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,609,604.00	37,774,156.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,627,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	834,376,886.00	942,351,631.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	834,376,886.00	942,351,631.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,407,400.00	57,602,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,407,400.00	57,602,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,102,699.00	95,364,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,102,699.00	95,364,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-4,249,137.99	205,494,722.50
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	508,995.87	12,517,732.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	508,995.87	12,517,732.19
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-4,758,133.86	192,976,990.31

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,063,172,090.00	2,325,919,084.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	898,427,486.00	1,031,148,084.30
120	Нийтлэг татварын бус орлого	898,427,486.00	1,031,148,084.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	895,827,486.00	1,031,148,084.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	895,827,486.00	1,031,148,084.30
120009	Бусад орлого	2,600,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,164,744,604.00	1,294,771,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,154,744,604.00	1,294,771,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,744,604.00	1,294,771,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,052,822,821.00	2,299,834,084.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,052,822,821.00	2,299,834,084.30
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,038,934,016.00	1,162,757,796.66
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	809,979,974.00	818,675,586.38
210101	Үндсэн цалин	641,273,274.00	580,212,986.38
210102	Нэмэгдэл	102,128,000.00	187,337,000.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	34,848,000.00	34,848,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,730,700.00	16,277,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,817,200.00	99,132,202.28
210201	Тэтгэврийн даатгал	58,782,012.73	66,235,675.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,041,667.84	8,268,428.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,859,804.82	6,567,454.36
210204	Ажилгүйдлийн даатгал	1,648,518.98	1,641,712.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,485,195.63	16,418,932.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,357,700.00	31,594,005.00
210301	Гэрэл, цахилгаан	6,492,600.00	12,014,295.00
210302	Түлш, халаалт	1,037,600.00	1,740,700.00
210304	Байрны түрээс	21,827,500.00	17,839,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,921,063.00	40,490,100.00
210401	Бичиг хэрэг	6,030,031.00	9,028,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,460,000.00	16,659,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,115,597.00	12,467,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	788,435.00	1,229,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,527,000.00	1,105,000.00
2105	Нормативт зардал	46,800,180.00	71,870,674.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,620,700.00	69,620,674.00
210502	Хоол, хүнс	2,179,480.00	2,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,212,800.00	57,827,099.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	36,990,500.00
210604	Урсгал засвар	4,212,800.00	20,836,599.00
2107	Томилолт, зочны зардал	9,618,870.00	9,535,030.00
210702	Дотоод албан томилолт	9,618,870.00	9,535,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,918,129.00	30,825,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	2,248,800.00

Замын Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	576,664.00	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	605,000.00	950,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,558,065.00	4,547,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,698,400.00	21,898,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	308,100.00	2,808,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	308,100.00	2,808,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,013,888,805.00	1,137,076,287.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,001,820.00	41,758,656.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,765,216.00	3,984,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,609,604.00	37,774,156.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,627,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	834,376,886.00	942,351,631.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	834,376,886.00	942,351,631.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,407,400.00	57,602,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,407,400.00	57,602,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,102,699.00	95,364,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,102,699.00	95,364,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,349,269.00	26,085,000.00
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,350,000.00	26,085,000.00
224001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,350,000.00	26,085,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,350,000.00	-26,085,000.00
87	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	0.00	0.00
88	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	0.00	0.00

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	485,979.11	-303,569,098.06	523,348,163.35
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-485,979.11	485,979.11	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,431,282.30	0.00	-303,083,118.95	523,348,163.35
4-07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,758,133.86	-4,758,133.86
4-01	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	0.00	-307,841,252.81	518,590,029.49
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,431,282.30	0.00	-307,841,252.81	518,590,029.49
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	5,677,361.23	0.00	5,677,361.23
4-05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
4-07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	192,976,990.31	192,976,990.31
4-08	Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4-09	Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
4-01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	-114,864,262.50	717,244,381.03

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,294,771,000.00	1,230,601,452.66	64,169,547.34	95.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,294,771,000.00	1,230,601,452.66	64,169,547.34	95.04
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,861,900.00	1,188,842,796.66	64,019,103.34	94.89
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	865,266,200.00	818,675,586.38	46,590,613.62	94.62
210101	Үндсэн цалин	626,803,600.00	580,212,986.38	46,590,613.62	92.57
210102	Нэмэгдэл цалин	187,337,000.00	187,337,000.00	0.00	100.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	34,848,000.00	34,848,000.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын цалин	16,277,600.00	16,277,600.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,834,300.00	99,132,202.28	4,702,097.72	95.47
210201	Тэтгэврийн даатгал	69,223,000.00	66,235,675.00	2,987,325.00	95.68
210202	Тэтгэмжийн даатгал	8,652,800.00	8,268,428.00	384,372.00	95.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,922,300.00	6,567,454.36	354,845.64	94.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,730,500.00	1,641,712.00	88,788.00	94.87
210205	Эрүүл мэндийн даатгал	17,305,700.00	16,418,932.92	886,767.08	94.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,283,400.00	31,594,005.00	12,689,395.00	71.35
210301	Гэрэл, цахилгаан	14,462,700.00	12,014,295.00	2,448,405.00	83.07
210302	Түлш, халаалт	1,740,700.00	1,740,700.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	28,080,000.00	17,839,010.00	10,240,990.00	63.53
2104	Хангамж, бараа материалын зардал	41,200,100.00	41,200,100.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	9,028,400.00	9,028,400.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	16,659,900.00	16,659,900.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,467,600.00	12,467,600.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,229,200.00	1,229,200.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,815,000.00	1,815,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	71,870,700.00	71,870,674.00	26.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,620,700.00	69,620,674.00	26.00	100.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,212,800.00	81,202,099.00	10,701.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,000,000.00	23,000,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	37,000,000.00	36,990,500.00	9,500.00	99.97
210604	Урсгал засвар	21,212,800.00	21,211,599.00	1,201.00	99.99
2107	Томиллолт, зочны зардал	9,535,700.00	9,535,030.00	670.00	99.99
210702	Дотоод албан томиллолт	9,535,700.00	9,535,030.00	670.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,850,600.00	32,825,000.00	25,600.00	99.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4,274,400.00	4,248,800.00	25,600.00	99.40

Замын Үүд сум дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	280,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	800,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.00	950,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,547,800.00	4,547,800.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,898,400.00	21,898,400.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,808,100.00	2,808,100.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	2,808,100.00	2,808,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,909,100.00	41,758,656.00	150,444.00	99.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,909,100.00	41,758,656.00	150,444.00	99.64
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,984,500.00	3,984,500.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,924,600.00	37,774,156.00	150,444.00	99.60
15	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,294,771,000.00	1,294,771,000.00	0.00	100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,294,771,000.00	1,294,771,000.00	0.00	100.00
13	Санхүүжилтийн орлого	1,294,771,000.00	1,294,771,000.00	0.00	100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,294,771,000.00	1,294,771,000.00	0.00	100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,294,771,000.00	1,294,771,000.00	0.00	100.00